

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН МЭНДЧИЛГЭЭ

Даян дэлхийн Тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн олон талт түншүүдийн
8 дугаар хуралдаанд оролцогчдод

Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид,
Хатагтай ноёд оо,
Та бүхний энэ өдрийн амрыг эрэн мэндчилье.

Мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх замаар хүнсний, аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулах, малчид, фермерүүдийн амьжиргааг дэмжих, тэдэнд эдийн засгийн боломж олгох, байгалийн нөөцийг үр ашигтайгаар ашиглаж сурах, байгаль цаг уурын өөрчлөлтөнд дасан зохицох, хүн, мал амьтан, байгаль орчны сайн сайхан байдлыг хангахын төлөө байгуулагдсан олон талт түншлэлийн 8 дугаар хурал Монгол улсад чуулж байна.

Дэлхийн хүн ам асар хурдтай өсөн нэмэгдэхийн хэрээр тэднийг хүрэлцээтэй хүнсээр тогтвортой хангахад мал аж ахуйн салбарын гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж байна.

Монгол улсын зүгээс бусад улс орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хэрэгжүүлснээр бүс нутгийнхаа хүнсний худалдаа, үүний дотор экологийн цэвэр хүнсээр хангах үйлсэд оруулах хувь нэмрээ цаашид ихээхэн нэмэгдүүлэх нөөц боломжтой юм.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал зорилт, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хүн ардаа эрүүл аюулгүй хүнсээр хангах зорилтыг тусган хэрэгжүүлж байна.

Мал аж ахуйн салбар нь хүн амыг хүнсээр, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах нэн чухал үүргийг гүйцэтгэдэг. 2017 оны байдлаар хөдөө аж ахуйн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 14,5 хувийг үйлдвэрлэж байна.

Монгол Улсын Засгийн газраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах тодорхой зорилтыг тавин ажиллаж байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх зорилгоор “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

Засгийн газраас баталсан “Мах, сүүний аян”-ыг зохион байгуулж бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг зохистой хослуулснаар мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

Засгийн газраас мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт, даатгал, татварын уян хатан бодлогоор дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад ирж байгаа хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлэхээр зорьж байна.

Жилээс жилд улам эрчимжиж байгаа уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор мал аж ахуйн салбар, үүний дотор бэлчээрийн мал аж ахуйн салбарыг цаашид тогтвортой хөгжүүлэх зорилт нь олон талын сорилт, бэрхшээлтэй тулгарахаар байна.

Бэлчээрийн мал аж ахуйд тулгуурласан Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын хувьд бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх нь эн тэргүүний чухал зорилтууд болж байна. Монгол Улсын Засгийн газар үүнд онцгой анхаарал хандуулж цаашид бэлчээрийн даацыг зохистой хадгалах, бэлчээрийн зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулахаар тусгайлан Бэлчээрийн тухай хуулийг боловсруулж, УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

Хэдийгээр өнөө цагт шинжлэх ухаан технологи өндөр хөгжилд хүрч техник технологийн салбарууд хурдацтай хөгжиж байгаа боловч хүн төрөлхтөн байгаль дэлхийтэйгээ салшгүй холбоотой учир бид хүрээлэн байгаа орчны хамгаалж, байгаль орчинд халгүй технологийг нэвтрүүлж, ашиглах шаардлагатай гэдгийг алхам тутамдаа санаж, ажил хэрэг болгох ёстой.

Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн олон талт түншүүдийн хуралдааныхаа явцад та бүхэн:

- Хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, бэлчээрийн мал аж ахуйгаас үйлдвэрлэсэн экологийн цэвэр, аюулгүй хүнсийг дэлхийн хэрэглэгчдэд хүргэх гарц боломжийг бүрдүүлэх;
- Уур амьсгалын нөлөөллийг бууруулах улмаар түүнд дасан зохицсон мал аж ахуй эрхлэхэд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, малчид, хөдөөгийн иргэдийн чадавхийг сайжруулах;

- Байгалийн нөөц, баялагаа өнөөгийн байгаль цаг уур, нийгэм, эдийн засгийн хөгжилтэй нийцүүлэн тогтвортой ашиглах;
- Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд нүүдлийн мал аж ахуйн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлуудад анхаарлаа хандуулна гэж найдаж байна.

Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн олон талт түншүүдийн 8 дугаар хурлын үйл ажиллагаанд өндөр амжилт хүсэж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ

2018 оны 6 дугаар сарын 11-ний өдөр